

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газар



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

НӨХӨН СОНГУУЛИЙН ЗАРДЛЫГ ХОЛБОГДОХ ЧИГЛЭЛИЙН ДАГУУ
ХУВААРИЛСАН БОЛОВЧ АРВИЛАН ХЭМНЭЛТГҮЙ ЗАРЦУУЛСАН
БАЙНА.

“Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2025 оны нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд аудит хийж, дүгнэлт гаргах”-д хийсэн нийцлийн аудит

АУДИТЫН КОД: ХЭА-2025/68-ШТА-НА

Хэрлэн сум 2025 он



**Аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор
Ж.Ганбаатар**

Утас: 70562112 Цахим хаяг: ganbaatarj@audit.gov.mn

Аудитын менежер Д.Оюунтуяа

Утас: 99775390 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn

Ахлах аудитор Д.Эрдэнэбилэг

Утас: 92116770 Цахим хаяг: erdenebilegd@audit.gov.mn

Аудитор Д.Эрдэнэтуяа

Утас: 99569599 Цахим хаяг: erdenetuyad@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу: Цахим хуудас: www.audit.mn

ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2025 оны 08 дугаар сарын 11

Дугаар 35

Чингис хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторов "Эрх шилжүүлэх тухай" 2023 оны А/102 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтын 1.4 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. "Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2025 оны нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд аудит хийж, дүгнэлт гаргах"-д хийсэн нийцлийн аудитын тайланг нэгдүгээр, хүргүүлсэн албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газар, аймгийн сонгуулийн хороо /А.Жаргалсайхан/-нд тус тус хүргүүлсүгэй.
3. Аудитаар өгсөн албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор /Д.Эрдэнэбилэг/-т даалгасугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Д.Оюунтуяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Ж.ГАНБААТАР

Хэнтий аймаг дахь Ерөнхий аудитын газрын
дарга, тэргүүлэх аудиторын 2025 оны
08 дугаар сарын 11 -ны өдрийн 35 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт



Албан шаардлагын жагсаалт

№	Байгууллагын нэр	Аудитын код	Албан шаардлагын дугаар	Дүн /төгрөг/
1	Аймгийн сонгуулийн хорооны дарга	ХЭА-2025/68-ШТА-НА	215/A2371125	5,402,250.00
ДҮН				5,402,250.00

АГУУЛГА

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	7
БҮЛЭГ 1. Орон нутгийн нөхөн сонгуульд зарцуулах зардлыг холбогдох дээд байгууллагууд төлөвлөн аймаг, сумын сонгуулийн хороо мөрдөж ажилласан байна.	10
1.1. Сонгуулийн Ерөнхий Хороо нөхөн сонгуулийн зардлыг тооцон ирүүлсэн байна.	10
1.2 Сонгуулийн Ерөнхий хорооноос хуваарилсан төсвийг ирүүлсэн чиглэлийн дагуу сумдад олгосон.	10
1.3 Улсын бүртгэлийн Ерөнхий газар бүртгэлийн ажилтнуудтай холбоотой зардлыг хуваарилсан бол цагдаагийн албан хаагчидтай холбоотой зардал хуваарилаагүй байна.....	11
БҮЛЭГ 2. Аймгийн сонгуулийн хороо нь нөхөн сонгууль зохион байгуулах зардлыг арвилан хэмнэлтгүй зарцуулсан байна.....	12
2.1. Батлагдсан төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан байна.	12
2.2. Аймаг, сумдын сонгуулийн хороод зардлын гүйцэтгэлийг эдийн засгийн ангиллын дагуу тайлагнасан байна.	13
2.3 . Сонгуулийн зардлын зарцуулалтад хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.	13
Холбогдох байгууллагын санал:	15
ДҮГНЭЛТ: 16	

	ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
СХ	Сонгуулийн хороо
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
УБХ	Улсын бүртгэлийн хэлтэс
ЦГ	Цагдаагийн газар

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	<i>Сонгуулийн Ерөнхий хорооноос ирүүлсэн төсвийн хуваарилалт</i>	9
Хүснэгт 2	<i>Сумдад хуваарилсан нөхөн сонгуулийн зардлын судалгаа</i>	10
Хүснэгт 3	<i>Нөхөн сонгуульд ажилласан улсын бүртгэлийн ажилтнуудын зардлын судалгаа</i>	11
Хүснэгт 4	Аймаг, сумын сонгуулийн хорооны нөхөн сонгуулийн төсөв, гүйцэтгэл	11
Хүснэгт 5	Бүртгэлийн ажилтнуудын нөхөн сонгуулийн зардлын төсөв, гүйцэтгэл	12

Хавсралтын товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт 1	<i>Арвилан хэмнэлтгүй зарцуулсан зардлын судалгаа</i>	15

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрх, “Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай” хуулийн 10 дугаар зүйлийн 10.8, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2025 оны А/44 дугаар тушаалыг тус тус үндэслэн нийцлийн аудитыг хийлээ.
Аудитын зорилт	Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2025 оны нөхөн сонгууль зохион байгуулахад улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилсан, зориулалтын дагуу арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэхийг тодорхойлоход аудитын зорилго чиглэгдэв. Аудитын зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: ➤ <i>Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх;</i> ➤ <i>Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгууль зохион байгуулахад улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг зориулалтын дагуу арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэх;</i>
Аудитын хамарсан хүрээ	Аудитад аймаг, сумын сонгуулийн хороод, УБХ, ЦГ, болон холбогдох бусад байгууллагууд болон сонгуульд зарцуулсан зардлын анхан шатны баримт, тайлан, олгосон санхүүжилтийг хамрууллаа.
Аудитын хязгаарлалт	
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэхэд нийцлийн аудитын стандарт АДБОУС 100, 400, 4000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт-Нийцлийн аудит MNS 6817:2020, Нийцлийн болон Санхүүгийн аудитын арга зүйг ашиглан улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтын талаар холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан, судалгаа, баримт материалд тулган баталгаажуулалт, дун шинжилгээ хийн аудитын судалгаа, хөтөлбөр, арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ж.Ганбаатар хянан удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежер Д.Оюунтуяа хэрэгжүүлэн, ахлах аудитор Д.Эрдэнэбилэг ахлан, аудитор Д.Эрдэнэтуяа төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв.

**Хүндрэл
бэрхшээл**

Аудитыг 2025 оны 6 дугаар сарын 25-ээс 8 дугаар сарын 11-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэн аудитын тайланг аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторовн тушаалаар баталгаажуулан 2025 оны 8 дугаар сарын 11-нд Үндэсний аудитын газар болон аймгийн Сонгуулийн хороонд хүргүүлэв.

.....

**АУДИТЫН ДҮН: НӨХӨН СОНГУУЛИЙН ЗАРДЛЫГ ХОЛБОГДОХ ЧИГЛЭЛИЙН
ДАГУУ ХУВААРИЛСАН БОЛОВЧ АРВИЛАН ХЭМНЭЛТГҮЙ ЗАРЦУУЛСАН
БАЙНА.**

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Хэнтий аймагт 2025 онд сумын ИТХ-ын Төлөөлөгчийг сонгох нөхөн сонгуулийг Батширээт, Норовлин, Батноров, Дархан, Дэлгэрхаан, Бор-Өндөр сумын 7 хэсгийн хороонд зохион байгуулагдсан.

Аймаг, сумын Сонгуулийн хороодод 38, хэсгийн хороодод 55, мэдээлэл технологийн багт 18, нийт 111 төрийн албан хаагч ажиллажээ.

Сонгуулийн Ерөнхий Хорооноос нөхөн сонгуулийн зардалд 143.9 сая төгрөг хуваарилан ирүүлснээс 140.4 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 3.5 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн бол Улсын бүртгэлийн ерөнхий газраас 8.9 сая төгрөгийг хуваарилагдсаныг бүрэн зарцуулсан байна.

Нөхөн сонгууль зохион байгуулах зардлаас 5.4 сая төгрөгийн шатахууны зардлыг албан томилолтоор ажиллах удирдамж батлуулаагүй, ажилласан тухай тайлан бичээгүй, СЕХорооноос ирүүлсэн нормативаас хэтрүүлэн зарцуулсан зэрэг нь төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулжээ.

БҮЛЭГ 1. Орон нутгийн нөхөн сонгуульд зарцуулах зардлыг холбогдох дээд байгууллагууд төлөвлөн аймаг, сумын сонгуулийн хороо мөрдөж ажилласан байна.

1.1. Сонгуулийн Ерөнхий Хороо нөхөн сонгуулийн зардлыг тооцон ирүүлсэн байна.

Аймаг, сумын ИТХ-ын төлөөлөгчийг сонгох орон нутгийн нөхөн сонгуулийг зохион байгуулах аймаг, сумын сонгуулийн хорооны төсвийг Сонгуулийн Ерөнхий хороо төлөвлөн 2025 оны 04 сарын 29-ны өдрийн 1/177 албан тоотоор 1 дэх хэсгийн 16,2 сая төгрөгийг, 2025 оны 05 сарын 23-ны өдрийн 3/230 албан тоотоор 2 дахь хэсгийн 24.9 сая төгрөгийг, 2025 оны 06 сарын 12-ны өдрийн 3/273 албан тоотоор 3 дахь хэсгийн 102.8 сая төгрөгийн төсвийн хуваарийг ирүүлсэн байна.

Хавсралт №1. Сонгуулийн Ерөнхий хорооноос ирүүлсэн төсвийн хуваарилалт /Төгрөг/

Эх сурвалж: СЕХ-ний Захирамжууд

Энэхүү төсвийн зардлыг тооцохдоо зарим зардлыг сонгуулийн хэсгийн хорооны тоогоор тооцож хуваарилсан.

Сонгуулийн ерөнхий хорооноос дээрх төсвийг аймгийн Сонгуулийн хороонд бүрэн олгосон байна.

Нөхөн сонгуулийн төсвийн зардлыг аймаг, сумын сонгуулийн хороо тооцоогүй, Сонгуулийн ерөнхий хороо төлөвлөж бүрэн шилжүүлсэн байна.

1.2 Сонгуулийн Ерөнхий хорооноос хуваарилсан төсвийг ирүүлсэн чиглэлийн дагуу сумдад олгосон.

Хэнтий аймагт 2025 онд зохион байгуулагдсан нөхөн сонгуулийн аймаг, сумын сонгуулийн хороонд 38, хэсгийн хороодод 55, мэдээлэл технологийн багт 18, нийт 111 төрийн албан хаагч ажилласан байна.

Сонгуулийн Ерөнхий хорооноос Хэнтий аймгийн 2025 оны нөхөн сонгуульд зарцуулахаар хуваарилсан зардлыг аймгийн Сонгуулийн хорооны 2025 оны 05 сарын 12-ны өдрийн А/02 Захирамжаар 10.9 сая төгрөг, 2025 оны 06 сарын 06-ны өдрийн А/05 Захирамжаар 24.9 сая төгрөг, 2025 оны 06 сарын 17-ны өдрийн А/07 Захирамжаар 102.8 сая төгрөгийг нөхөн сонгууль зохион байгуулагдах Бор-Өндөр, Дархан, Батноров, Норовлин, Дэлгэрхаан, Батширээт сумдад болон аймгийн сонгуулийн хороонд хуваарилсан байна.

Аймгийн Сонгуулийн хороо 2025 оны 06 сарын 17-ны өдрийн А/08 тоот Захирамжаар Бор-Өндөр сумын 2 дахь хэсгийн хороонд 1.1 сая төгрөгийг нэмж хуваарилсан байна. Сумын хэсгийн хороодод төсвийг хуваарилахдаа СЕХ-ны албан тоотод дурдсан төсвийн зарцуулалтын чиглэлийг мөрдсөн байна.

Хавсралт №2: Сумдад хуваарилсан нөхөн сонгуулийн зардлын судалгаа /Төгрөг/

д/д	Сумын нэр	Хэсгийн хорооны тоо	Хуваарилагдсан зардал
1	Аймгийн Сонгуулийн хороо	1	39,531,800.0
2	Дархан сумын СХ	2	15,130,400.0
3	Дэлгэрхаан сумын СХ	2	16,765,600.0
4	Батширээт сумын СХ	2	15,130,400.0
5	Норовлин сумын СХ	2	16,765,600.0
6	Батноров сумын СХ	2	16,765,600.0
7	Бор-Өндөр сумын СХ	3	23,801,200.0
	НИЙТ ДҮН	14	143,890,600.0

Эх сурвалж : Аймгийн Сонгуулийн хорооны Захирамжууд

Нийт зардлын 27.4 хувь буюу 39.5 сая төгрөгийг аймгийн сонгуулийн хороонд, 72.6 хувь буюу 104.4 сая төгрөгийг сумын хэсгийн хороодод олгосон байна.

1.3 Улсын бүртгэлийн Ерөнхий газар бүртгэлийн ажилтнуудтай холбоотой зардлыг хуваарилсан бол цагдаагийн албан хаагчидтай холбоотой зардал хуваарилаагүй байна.

Орон нутагт нөхөн сонгууль зохион байгуулахтай холбоотойгоор Улсын бүртгэлийн Ерөнхий газрын даргын 2025 оны 05 сарын 07-ны өдрийн А/82 албан тоотойр шаардагдах зардлын төсвийг баталсан байна. Тус тушаалаар Хэнтий аймагт 2025 онд зохион байгуулагдах нөхөн сонгуульд 8.9 сая төгрөгийг зарцуулахаар хуваарилсан байна.

Хавсралт 3. Нөхөн сонгуульд ажилласан улсын бүртгэлийн ажилтнуудын зардлын судалгаа /Төгрөг/

№	Аймгийн нэр	Мөнгөн урамшуулал /мян.төг/	Бичиг хэрэг, бусад зардал	Тээвэрлэх болох шуурхай багийн зардал
1	Хэнтий аймаг УБХ	6,187,500.0	2,400,000.0	280,000.0
	Нийт дүн			8,867,500.0

Эх сурвалж: УБЕГ-ын даргын 2025оны 05 сарын 07-ны №А/82 тоот тушаал

Хэнтий аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нөхөн сонгуульд ажилласан ажилтнуудын урамшуулал, НДШ-д 5,625.0 мянган төгрөг, сонгогчдын нэрсийн жагсаалт хэвлэх, хүргэхэд 1,572.5 мянган төгрөг, сургалтад оролцсон ажилтнуудын шатахууны зардалд 1,270.0 мянган төгрөг, тоног төхөөрөмж авах, хүргэхэд 400.0 мянган төгрөгийн зарцуулахаар тус тус хуваарилжээ.

БҮЛЭГ 2. Аймгийн сонгуулийн хороо нь нөхөн сонгууль зохион байгуулах зардлыг арвилан хэмнэлтгүй зарцуулсан байна.

2.1. Батлагдсан төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан байна.

Хэнтий аймгийн Сонгуулийн хороо нь Сонгуулийн ерөнхий хорооны тамгын газрын 2025 оны 1/177, 3/230, 3/273 тоот албан бичгээр ирүүлсэн төсвийн зориулалтын тайлбарт заасны дагуу Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны нөхөн сонгуулийг зохион байгуулахтай холбоотой зардлыг санхүүжүүлсэн байна.

Хүснэгт 4: Аймаг, сумын сонгуулийн хорооны нөхөн сонгуулийн төсөв, гүйцэтгэл /Төгрөг/

№	Зардлын нэр	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Үлдэгдэл
1	Маягт албан бичгийн хэвлэмэл хуудас, үнэмлэх хэвлүүлэх зардал	290,000.0	290,000.0	-
2	Сургалтын зардал	1,425,000.0	1,425,000.0	-
3	Бичиг хэрэг	2,450,000.0	2,450,000.0	-
4	Шуудан холбоо	3,200,000.0	3,200,000.0	-
5	Унааны зардал	8,800,000.0	7,423,800.0	1,376,200.0
6	Санал авах байр бэлтгэх зардал	2,100,000.0	2,093,000.0	7,000.0
7	Сурталчилгааны зардал	4,900,000.0	4,084,800.0	815,200.0
8	Саналын хуудас, төхөөрөмж авах хүргэх зардал	15,666,000.0	14,646,000.0	1,020,000.0
9	МТБ-ийн гишүүний холбоо, унааны зардал	1,250,000.0	1,250,000.0	-
10	Эрчим хүчний эх үүсгэвэр бэлтгэх	980,000.0	801,920.0	178,080.0
11	Сонгуулийн хороодын урамшуулал, хоолны зардал	77,772,800.0	77,772,800.0	-
12	МТБ-ийн гишүүн, даамлын урамшуулал, хоолны зардал	15,052,800.0	15,052,800.0	-
13	Томилолтын зардал	5,704,000.0	5,631,500.0	72,500.0
14	Шуурхай багийн зардал	4,300,000.0	4,300,000.0	-
	ДҮН	143,890,600.0	140,421,620.0	3,468,980.0

Эх сурвалж: Аймгийн сонгуулийн хорооны төсвийн гүйцэтгэл

Хэнтий аймгийн Сонгуулийн хороо нь Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан төсвөөс 140.4 сая төгрөгийг зарцуулж 3.5 сая төгрөгийг Сонгуулийн ерөнхий хорооны дансанд буцаан төвлөрүүлсэн байна.

Аймгийн Сонгуулийн хороо, сумдын Сонгуулийн хороодын сонгууль зохион байгуулахтай холбогдсон зардлын зарцуулалтыг дансны хуулга, зардлын тайлан, анхан шатны баримтуудтай тулган шалгахад СЕХ-ны даргын Захирамжаар баталсан “Аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны төсвийн зарцуулалтын тухай тайлбар”-т унааны зардал сумдад олгох болон хуваарилсан төсвийг хэмнэлтэй зарцуулж, санхүүгийн анхан шатын баримтыг НББ тухай хуульд заасны дагуу бүрдүүлж ажиллах талаар заагдсан боловч хэрэгжүүлж ажиллаагүй 5,4 сая төгрөгийн шатахууны зардлыг анхан шатны баримтын бүрдэл хангаагүй, СЕХорооноос ирүүлсэн нормативаас илүү зарцуулж арвилан хэмнэлтгүй ажилласан байна.

Аймгийн сонгуулийн хорооны гишүүд сумдад ажиллахдаа 2,1 сая төгрөгийн шатахууныг анхан шатны баримтын бүрдэл хангаагүй зарцуулсан, 2.8 сая төгрөгийг аймгийн сонгуулийн хорооны даргын захирамжид заагдсан сумдын хэсгийн хороонд ажиллах чиглэлийг давхардуулан илүү олгосон, 0,4 сая төгрөгийг

СЕХорооноос ирүүлсэн төсвийн зарцуулалтын тайлбарыг баримтлаагүй зарцуулсан зэрэг нийт 5,4 сая шатахууныг арвилан хэмнэлтгүй зарцуулсан зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

Хэнтий аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн нэмэлт санхүүжилтийн дансанд нөхөн сонгууль зохион байгуулахтай холбоотойгоор 8.9 сая төгрөгийн санхүүжилт хуваарилагдсаныг холбогдох хууль, журмын дагуу анхан шатны баримтыг бүрдүүлэн бүрэн зарцуулсан байна.

Хүснэгт 5: Бүртгэлийн ажилтнуудын нөхөн сонгуулийн зардлын төсөв, гүйцэтгэл /Төгрөг/

№	Зардлын ангилал	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү
1	Улсын бүртгэлийн байгууллагын ажилтан, итгэмжлэгдсэн ажилтны болон гэрээт ажилтны мөнгөн урамшуулал, хоол, унааны зардлын төсөв	6,187,500.0	6,187,500.0	0.0
2	Сонгогчдын нэрийн жагсаалт хэвлэх, бичиг хэргийн болон бусад зардал	2,400,000.0	2,400,000.0	0.0
3	Техник хэрэгслийг тээвэрлэх турших болон шуурхай багийн зардал	280,000.0	280,000.0	0.0
	ДҮН	8,867,500.0	8,867,500.0	0

Эх сурвалж: Улсын бүртгэлийн хэлтсийн төсвийн гүйцэтгэл

2.2. Аймаг, сумдын сонгуулийн хороод зардлын гүйцэтгэлийг эдийн засгийн ангиллын дагуу тайлагнасан байна.

Аймаг, сумын Сонгуулийн хороод нь Сонгуулийн Ерөнхий хорооны даргын 2025 оны 06 дугаар сарын 17-ний өдрийн А/33 дугаар Захирамжаар баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын хавсралтаар батлагдсан маягтаар сонгуулийн зардлын тайлангаа гаргасан байна.

Сонгуулийн зардлын гүйцэтгэлийг эдийн засгийн ангиллын дагуу тайлагнасан эсэхийг шалгахад зөрчил илрээгүй.

Аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст хуваарилсан нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдон гарах зардлыг хянан үзэхэд батлагдсан төсвийн хүрээнд зориулалтын дагуу бүрэн зарцуулсан байна.

Нөхөн сонгуулийн байр тохижуулах зардлаар худалдан авсан эд материалын зүйлс болон эрчим хүчний эх үүсвэр бэлтгэхтэй холбоотой шатахууны үлдэгдлийг аймгийн Засаг даргын тамгын газар, сумдын Засаг даргын тамгын газарт хүлээлгэн өгч, тухайн байгууллагууд бараа материалд бүртгэн хүлээж авсан байна.

2.3. Сонгуулийн зардлын зарцуулалтад хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.

Аймгийн хэмжээнд нөхөн сонгууль зохион байгуулах зардлын гүйлгээний баримт дээр нэгдүгээр гарын үсгийг сонгуулийн хорооны дарга, хоёрдугаар гарын үсгийг томилогдсон нягтлан бодогч нар зурж баталгаажуулан ажилласан байна.

Хэнтий аймгийн сонгуулийн хороо нь сумдын сонгуулийн хороонд зардлын санхүүжилт, зардлын гүйцэтгэлийн аргачлал, зөвлөмж, чиглэлийг тухай бүр хүргүүлэн хяналт тавьж ажилласан байна.

Сонгуулийн хороодод нэгдсэн журмаар Төрийн санд түр данс нээж, зардлын гүйлгээнд аймаг, сумын Төрийн сангийн мэргэжилтэн хяналт тавьж баталгаажуулан ажилласан байна.

Холбогдох байгууллагын санал:


**ХЭНТИЙ АЙМГИЙН
СОНГУУЛИЙН ХОРОО**
Залуучуудын гудамж-01, Баянмөнх баг
Хэрлэн сум, Хэнтий аймаг, 23117
Утас/Факс: (976) 70562412
Цахим шуудан: infoazdtg@khentii.gov.mn
2023.08.08 № 15
танай _____-ны № _____-т

**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

“Аймаг нийслэл сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд аудит хийж, дүгнэлт гаргах”-д хийсэн нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тайлангийн төсөлд ямар нэгэн саналгүй болно.

ДАРГА  А.ЖАРГАЛСАЙХАН

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

- Орон нутгийн нөхөн сонгуулийн зардлыг СЕХ-оос ирсэн чиглэлийн дагуу хуваарилсан байна.
- Батлагдсан төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан байна.
- Нөхөн сонгуулийн зардлыг эдийн засгийн ангиллын дагуу тайлагнасан байна.
- Аймгийн Сонгуулийн хороо нь зардлын гүйцэтгэлийн талаарх зөвлөмж, чиглэлийг өгч, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна.

Арвилан хэмнэлтгүй зарцуулсан зардлын тооцоо /2025/

№	огноо	Зарцуулсан ажилтны нэр	Улсын дугаар	Хаана ажилсан	Явсан зай /км/	Шатахууны төрөл	Шаардах хуудсаар тооцсон		Зөрчлийн төрөл				
							Литр	мөнгөн дүн	Ажлын удирдамжгүй	Илтгэх хуудасгүй	Тайлан гаргаагүй	Давхардуулан шатахуун	СЕХ-ын аргачлалаас илүү ноомоор зарцуулсан
1	2025.5.29	Б.Золбоо	75-19 ХЭА	Чингис-Дэлгэрхаан-Чингис	500	түлш	100	305,000.0		1	1		
						масло	2	60,000.0		1	1		
2	2025.5.28	Ж.Энхбат	01-00 ХЭН	Чингис-Батноров-Чингис	300	A92	75	204,000.0		1	1		
						масло	1	30,000.0		1	1		
3	2025.5.30	Ж.Энхбат	01-00 ХЭН	Чингис-Норовлин-Чингис	600	A92	150	408,000.0	1	1	1		
						масло	2	60,000.0	1	1	1		
4	2025.6.05	Б.Ариунбаатар	77-85 ХЭҮ	Норовлин	400	A92	75	204,000.0		1	1		
5	2025.6.04	Ж.Энхбат	00-23 ХЭҮ	Батноров	200	A92	40	108,800.0		1	1		
6	2025.6.04	С.Баттөмөр	77-85 ХЭҮ	Батширээт	380	A92	70	190,400.0		1	1		
7	2025.6.03	Н.Үнэнбат	77-85 ХЭҮ	Дэлгэрхаан	300	A92	55	149,600.0		1	1		
8	2025.6.05	С.Баттөмөр	12-68 ХЭҮ	Дархан	344	A92	72	195,840.0		1	1		
9	2025.6.02	З.Наранцацрал	62-26 ХЭҮ	Бор-Өндөр	376	A92	70	190,400.0		1	1		
10	2025.6.13	Ж.Энхбат	00-23 ХЭҮ	Улаанбаатар	850	A92	170	462,400.0			1	1	1
11	2025.6.15	Бат-Орших /Цагдаа Базарцогт/	00-03 ХЭА	Чингис-Бор-Өндөр-Дархан-Дэлгэрхаан	940	A92	188	511,360.0				1	
12	2025.6.23	Г.Энхбат	85-91 УБО	Батширээт	420	түлш	105	320,250.0					1
13	2025.6.23	Г.Ганболд	11-28 ХЭҮ	Дархан сум	400	A92	80	252,000.0					1
14						масло	2	68,000.0					1
15	2025.6.23	Батзориг	88-72 УНВ	Дэлгэрхаан	400	A92	100	282,000.0					1
16						масло	2	38,000.0					1
17	2025.06.23	Л.Энхдорж	05-09 ХЭН	Норовлин	400	A92	70	198,800.0					1
18						масло	4	121,200.0					1
19	2025.06.22	Б.Энхжаргал	47-30 ХЭА	Батноров	400	A92	100	282,000.0					1
20						масло	2	38,000.0					1
21	2025.06.23	Түмэнцэцэг	01-56 ХЭА	Бор-Өндөр	400	A92	100	287,000.0					1
22	2025.06.20	Үнэнбат/ Ж.Энхбат /	00-23 ХЭҮ	Батширээт	380	A92	80	217,600.0				1	
23	2025.06.20	Ж.Энхбат /Үнэнбат/	08-51 УНС	Норовлин	400	A92	80	217,600.0				1	
Нийт дүн								5,402,250.0					



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 08 сарын 11

Дугаар 215/А2371125

Чингис хот

ХТА-2025/68-ШТА-НА

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд "Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2025 оны нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд аудит хийж, дүгнэлт гаргах"-д хийсэн нийцлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Аймгийн сонгуулийн хорооны гишүүд сумдад ажиллахдаа 2.1 сая төгрөгийн шатахууныг анхан шатны баримтын бүрдэл хангаагүй зарцуулсан, 2.8 сая төгрөгийг аймгийн сонгуулийн хорооны даргын захирамжид заагдсан сумдын хэсгийн хороонд ажиллах чиглэлийг давхардуулан илүү олгосон, 0.4 сая төгрөгийг СЕХорооноос ирүүлсэн нормативаас хэтрүүлэн зарцуулсан зэрэг нийт 5.4 сая төгрөгийн шатахууны зардлыг арвилан хэмнэлтгүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" хэсгийг зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Аймгийн сонгуулийн хорооны дарга А.Жаргалсайхан, нягтлан бодогч Э. Ариунтунгалаг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Ж.ГАНБААТАР

Д.ЭРДЭНЭТУЯА

